



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/118

Мандалговь

“Гуа орд” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/70 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих ажил”-ын багц-1 (Дундговь, Баянжаргалан сум) гүйцэтгэгчээр шалгарсан “Гуа-Орд” ХХК-тай 104,637,661 (нэг зуун дөрвөн сая зургаан зуун гучин долоон мянга зургаан зуун жаран нэг) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Баталсан ажлын зураг, төсвийн дагуу “Өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих ажил”-ын багц-1 (Дундговь, Баянжаргалан сум) чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Гуа-Орд” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Г.Наранбат)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Баянжаргалан сумын Засаг дарга (Т.Цэвэлмаа) нарт ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060492